



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

**Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 27,476,021,690.00 (хорин долоон тэрбум дөрвөн зуун далан зургаан сая хорин нэгэн мянга зургаан зуун ер) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Гэмтэл согог судлалын үндэсний төвд эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хүлээлцэх, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132001155  
15-r huraldaan.docx



Төрийн өмчийн бөрдлого, зохихуулаагын газрын  
2025 оны... дугаар сарын...ны/ний өдрийн  
дүгээр тогтооллын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН  
ТӨРИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

| №        | Төсөл, арга хэмжээний нэр, байршил                                                                                                                                                                                              | Төсөл, арга хэмжээний хүчин чадал                                                                                                                                                                                                                                                                                                                           | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)                                                                       | Улсын комиссын акт     |                                                                                       | Бүртгэх байгууллага                                                                                                     |
|----------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|---------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|          |                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |                                                                                                            | Огноо                  | Дугаар, гүйцэтгэгч                                                                    |                                                                                                                         |
| 1        | Улаанбаатар, Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн харъяа Түлэнхийн төвийн барилга. (УБ хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн өөрийн эзэмшлийн газар дээр) | Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, өндөр төвөгшилтэй, А блок зоорьтой, 5 давхар, 250 ортой, тэнхлэгээрээ 30.8м*15м, В блок 7 давхар, 240 ортой, тэнхлэгээрээ 50.4м*30.4м, зоорьтой, С блок 24.0м*12.0м, зоорьтой, 1 давхар (гадна цахилгааны шугам, гадна дулаан, цэвэр усны шугам, гаднаариутгах татуурга, дэд өртөө, гадна зам талбай, ногоон байгууламж) | 27,476,021,690.00                                                                                          | 2022.05.23, 2023.02.15 | БА-119/2022 (Цаст консракшин ХХК А,С блок), БА-045/2023 Нутгийн зам групп ХХК В блок) | Гэмтэл согог судлалын үндэсний төв (Улаанбаатар, Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороо, Гэмтэл согог судлалын үндэсний төв) |
| НИЙТ ДҮН |                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 27,476,021,690.00<br>(хорин долоон тэрбум дөрвөн зуун далан зургаан сая хорин нэгэн мянга зургаан зуун ер) |                        |                                                                                       |                                                                                                                         |